

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өмч, эд хөрөнгийн 2025 оны эхний хагас жилийн нэгдсэн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн;
Гишүүд:	Газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн; Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн; Инженерийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн; Программ хангамж, сүлжээний ажилтан;

Нарийн бичгийн

Ахлах нягтлан бодогч

2. Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 12-ноос 26-ны хооронд холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тооллогын нэгдсэн дүнг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн дотор танилцуулахыг Комисст үүрэг болгосугай.

3. Тооллогын комиссын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Ю.Нанжид)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БОЛОРТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
НЯРАВ

Г.АНУДАРЬ